



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ОРА-2021/1/СТА-ЗГТС

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Аудитор: Г.Оргилмөрөн

Утас:70350757

Цахим хаяг:orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ТББ	Төрийн бус байгууллага
УЗН	Улаан загалмайн нийгэмлэг
ХТГИ	Хамтдаа тэмүүлэх гэрэлт ирээдүй
АМЭ	Архидалт мансуурлын эсрэг

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
3.Аудитын тайлан .....	7
3.1. Ерөнхий зүйл .....	7
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	7
3.4. Материаллаг байдал .....	7
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	8
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	9
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	9
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	10
3.9. Аудитын илрүүлэлт .....	10
Залруулсан алдаа .....	10
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	10
Аудитын зөвлөмж .....	11
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	11
4. Менежментийн захидал .....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	13

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.24 № 15

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,  
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ГАЗРЫН ДАРГА Х.ЭРДЭНЭБАТ  
ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.



### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>69,465,358.90</b>	<b>57,697,723.21</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	12,212,360.00	504,724.31
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	12,212,360.00	504,724.31
3121	<b>Төгрөг</b>	12,212,360.00	504,724.31
31211	Төрийн сангийн харилцах	12,212,360.00	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах		504,724.31
33	<b>АВЛАГА</b>	57,252,998.90	57,192,998.90
335	<b>Бусад авлага</b>	57,252,998.90	57,192,998.90
3351	Байгууллагаас авах авлага	57,192,998.90	57,192,998.90
3352	Хувь хүмүүсээс авах авлага	60,000.00	0.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>69,465,358.90</b>	<b>57,697,723.21</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>12,212,360.00</b>	<b>0.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	12,212,360.00	0.00
413	<b>Өглөг</b>	12,212,360.00	0.00
4136	<b>Бусад өглөг</b>	12,212,360.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	12,212,360.00	0.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>57,252,998.90</b>	<b>57,697,723.21</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	57,252,998.90	57,697,723.21
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	57,252,998.90	57,697,723.21
51210	Өмнөх үеийн үр дүн	-63,428,300.00	57,252,998.90
51220	Тайлант үеийн үр дүн	120,681,298.90	444,724.31
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>69,465,358.90</b>	<b>57,697,723.21</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>14,227,578,371.31</b>	<b>14,588,205,504.30</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,119,371.31</b>	<b>10,419,531.30</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	17,119,371.31	10,419,531.30
120002	Хүүгийн орлого	17,119,371.31	6,505,731.30
120009	Бусад орлого		3,913,800.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,210,459,000.00</b>	<b>14,577,785,973.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	14,210,459,000.00	14,577,785,973.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	14,210,459,000.00	14,577,785,973.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>14,106,897,072.41</b>	<b>14,587,760,779.99</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,106,897,072.41</b>	<b>14,587,760,779.99</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	6,804,550.00	3,911,450.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,804,550.00	3,911,450.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,804,550.00	3,911,450.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	14,100,092,522.41	14,583,849,329.99
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	14,046,730,347.00	14,435,147,520.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	14,046,730,347.00	14,435,147,520.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	53,362,175.41	148,701,809.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,362,175.41	148,701,809.99
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>120,681,298.90</b>	<b>444,724.31</b>



5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>120,681,298.90</u></b>	<b><u>444,724.31</u></b>
---	--------------------------------	------------------------------	--------------------------

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>14,261,047,581.31</u></b>	<b><u>14,598,232,694.30</u></b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>50,588,581.31</b>	<b>20,446,721.30</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	50,588,581.31	20,446,721.30
120002	Хүүгийн орлого	17,119,371.31	6,505,731.30
120009	Бусад орлого	33,469,210.00	13,940,990.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,210,459,000.00</b>	<b>14,577,785,973.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	14,210,459,000.00	14,577,785,973.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	14,210,459,000.00	14,577,785,973.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>14,248,835,221.31</u></b>	<b><u>14,609,940,329.99</u></b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,248,835,221.31</b>	<b>14,609,940,329.99</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,804,550.00</b>	<b>3,911,450.00</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,804,550.00	3,911,450.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,804,550.00	3,911,450.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,242,030,671.31</b>	<b>14,606,028,879.99</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	14,188,668,495.90	14,457,327,070.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	14,188,668,495.90	14,457,327,070.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	53,362,175.41	148,701,809.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,362,175.41	148,701,809.99
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>12,212,360.00</u></b>	<b><u>-11,707,635.69</u></b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	12,212,360.00	-11,707,635.69
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0.00	12,212,360.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	12,212,360.00	504,724.31

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-63,428,300.00	0.00	-63,428,300.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-63,428,300.00	0.00	-63,428,300.00
C07	Тайлант үеийн үр дүн			120,681,298.90		120,681,298.90
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	57,252,998.90	0.00	57,252,998.90

D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	57,252,998.90	0.00	57,252,998.90
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	57,252,998.90	0.00	57,252,998.90
D08	Тайлант үеийн үр дүн			444,724.31		444,724.31
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	57,697,723.21	0.00	57,697,723.21

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	14,577,785,973.00	14,451,271,330.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	14,577,785,973.00	14,451,271,330.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,500,000.00	3,911,450.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,500,000.00	3,911,450.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,500,000.00	3,911,450.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	14,573,285,973.00	14,447,359,880.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	14,573,285,973.00	14,447,359,880.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	14,573,285,973.00	14,447,359,880.00
13	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	14,577,785,973.00	14,439,058,970.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	14,577,785,973.00	14,439,058,970.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	14,577,785,973.00	14,439,058,970.00
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0.00	12,212,360.00
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		504,724.31

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Х.Эрдэнэбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оргилмөрөн хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ний өдрийн 01/116 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Орхон аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ үйл ажиллагааны чиглэлийг Нийгмийн халамжийн тухай хуулиар тодорхойлжээ. Тайлант хугацаанд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Орхон аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсөл, тусгай сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 2020 онд Орхон аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансанд дотоод аудит хийгээгүй байна.

Орхон аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

#### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.2 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 7,455,678.8 мянган төгрөгөөс 0.2 хувиар буюу 14,911.4 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд хувь хэмжээг өөрчлөөгүй бөгөөд нийт орлогын дүн жилийн дүн тул 14,588,205.5 мянган төгрөгөөс 0.2 хувиар буюу 29,176.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 124,293.2 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна. Нийт хөрөнгийн бууралт нь тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,212.3	504.7	-11,707.6
Авлага	57,253.0	57,193.0	-60.0
Урьдчилгаа			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
<b>Нийт хөрөнгө</b>	<b>69,465.3</b>	<b>57,697.7</b>	<b>-11,767.6</b>
Өр төлбөр	12,212.3	0	-12,212.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	57,253.0	57,697.7	444.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>69,465.3</b>	<b>57,697.7</b>	<b>-11,767.6</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 504.7 мянган төгрөг болж 11,707.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд олгогдоогүй халамжийн 12,212.3 мянган төгрөгийн өглөгийг бүрэн олгосон ба оны эцэст үлдэгдлийг төвлөрүүлснээс хойш харилцах дансанд хүүгийн орлого орж ирснээс шалтгаалжээ.

Авлага данснаас өмнөх онд үүссэн 60.0 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага төлөгдсөн байна. Капитал банкин дахь харилцах дансуудын үлдэгдлийг 2019 онд татах төвлөрүүлэх үед тус банкны төлбөр гүйцэтгэх чадамжгүйн улмаас үүссэн халамжийн тэтгэврийн болон алдарт эхийн одонгийн дансны үлдэгдэл 57,193.0 мянган төгрөг авлагаар бүртгэлтэй бөгөөд Капитал банк дахь банкны эрх хүлээн авагчийн 2019.11.29-ны өдрийн 2347 дугаар албан бичгээр Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.8 дахь хэсэгт заасан төлбөрийн дараалалд бүртгэгдэж, 57,193.0 мянган төгрөгөөр нэхэмжлэх баталгаажсан тухай илэрхийлсэн байна.

Өмнөх оны олгогдоогүй халамжийн мөнгөний 12,212.3 мянган төгрөгийн өглөгийг бүрэн олгож өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 0 төгрөг болсон бөгөөд тайлант онд өглөг үүсгээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 57,697.7 мянган төгрөг болж 444.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 360,627.1 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн байна.

Өмнөх оноос орлого өссөн нь Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг Ковид -19 цар тахалтай холбоотойгоор нэмэгдүүлэн олгож байгаагаас шалтгаалсан байна.

Нийт зардлын дүнд Нийгмийн халамжийн тэтгэвэр 1,591,423.2 мянган төгрөгөөр, Нийгмийн халамжийн тэтгэмж 843,729.9 мянган төгрөгөөр, нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөрийн зардал 972,263.7 мянган төгрөгөөр, ахмад настны тухай хуулийн дагуу олгох халамжийн үйлчилгээ 85,024.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 2-р сараас э-халамж системээр ХХҮЕГ-аас шууд олгогдож эхэлсэн тул 3,063,923.8 мянган төгрөгөөр, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу зарцуулах халамжийн үйлчилгээ 82,725.4 мянган төгрөгөөр буурсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 17,554,411.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 17,554,411.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,773,232.8 мянган төгрөгөөр бууруулж 14,781,178.8 мянган төгрөгөөр баталсан ба 2020 оны 02-р сараас жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 насны хүүхдээ асарч буй эхэд олгох тэтгэмж ХХҮЕГ-аас олгогдож эхэлсэн, Ковид -19-той холбоотойгоор 2020 оны 04-р сараас ЗГ-ын шийдвэрээр зарим төрлийн халамжийн үйлчилгээний мөнгөн дүнг нэмэгдүүлж олгосон зэрэг өөрчлөлт орсон тул төсвийг дахин тодотгож 203,392.8 мянган төгрөгөөр бууруулж оны эцэст 14,577,786.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Нийгмийн халамжийн үйлчилгээг санхүүжүүлэхээр 14,577,786.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 14,577,786.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 14,577,786.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардалд 14,447,359.9 мянган төгрөгийг зарцуулж 138,727.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнээс мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 12,212.4 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд оны эцэст харилцах дансны үлдэгдэл бодогдож орж ирсэн хүүгийн орлогын 504.7 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 14,451,271.3 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа хоцроосон 5 мэдээлэл байна.

Түр хоноглох үйлчилгээ болон ТББ-аас зохион байгуулж буй сургалтын өссөн дүнгээр 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авалтын мэдээллийг холбогдох талбарт

мэдээлдэггүй байна. Тухайлбал тайланд онд ХТГИрээдүй ТББ-ийн түр хоноглох үйлчилгээний 34,390. мянга, АМЭсрэг МБ АССОЦИАЦИ ТББ-ийн түр хоноглох үйлчилгээний 5,910.0 мянга, УЗНийгэмлэг ТББ-ийн сургалт, үйлчилгээний 6,881.0 мянган төгрөгийн буюу нийт 47,181.0 мянган төгрөгийн 3 худалдан авалтыг мэдээлээгүй байна. Мөн цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш зардлын 214,905.7 мянган төгрөгийн 28 гүйлгээг нөхөж мэдээлэв.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага өгөөгүй байна. Аудитаар өгсөн 0 төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	2	0	2	0	0	0	0
Нийт дүн	2	0	2	0	0	0	0

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,800.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12,212.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 390.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 391.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, 8,807.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс санхүүжүүлсэн нийгмийн халамжийн үйлчилгээний 12,212.3 мянган төгрөгийг дутуу илэрхийлсэн байсныг залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 9,588.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 390.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 391.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өглөө. Үүнд:

1. Халамжийн үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээний дагуу аймгийн Улаан загалмайн хорооноос зохион байгуулсан зорилтот сургалтад оролцогчдод олгогдоогүй унааны зардлын 390.0 мянган төгрөгийг нэг суралцагчийн сургалтын зардлын дээд хэмжээг хэтрүүлэн бичиг хэргийн болон цайны зардалд нэмж илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалт, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2020 оны А/58 дугаар тушаалаар батлагдсан “Гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлол аргачлал”-ын 1.6-д заасан нэг суралцагчийн сургалтын зардлын дээд хэмжээтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон ба аудитын явцад төлж барагдуулсан.

2. Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшууллыг батлагдсан төсвөөс 391.2 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 8,807.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### *1. Дотоод аудиттай холбоотой асуудал*

##### 1.1. Илрүүлэлт:

Халамжийн үйлчилгээ үзүүлэх олголтын жагсаалтаас 8,807.4 мянган төгрөгийн үйлчилгээг банк руу илгээсний дараа цуцлахдаа хэрхэн ямар шалтгаанаар цуцалснаа тайлбарлаагүй байна. Мөн халамжийн мөнгөний олголтыг банкнууд дээрх тухайлсан халамжийн сангийн данснаас шууд зарлага гаргаж олгож байгаа нь халамжийн мөнгө зорилтот иргэндээ хүрэхгүй байх эрсдэлийг нэмэгдүүлэхээс гадна халамжийн мөнгө бүгд иргэдийн дансанд шууд ордоггүйтэй холбоотойгоор өөрийн биеэр банк орж амжаагүй иргэдийн халамжийн мөнгийг олголтын жагсаалтаас банк руу илгээсний дараа цуцлаад, дахин өргөдөл гаргуулж /чирэгдэл учрах/ дараа жилийн төсвөөс нөхөж олгож байна.

##### 1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг төсвийн жил дамнан зарцуулах, төсөвт нэмэлд ачаалал үүсэх, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, холбогдох хууль тогтоомж зөрчих

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Халамжийн мөнгийг банк руу илгээсний дараа цуцлах бол тайлбар шалтгааныг тодорхой бичиж байх, иргэдэд олгохдоо банкин дахь халамжийн тухайн төрлийн данснаас зардал гаргаж олгох бус иргэний нэр дээрх дансанд шууд ордог байдлаар зохион байгуулах.

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн захирагчийн 2021.02.24-ны өдрийн 01/290 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

#### *2. Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин*

##### 2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 талбарын мэдээллээс 5 талбарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Түр хоноглох үйлчилгээ болон ТББ-аас

зохион байгуулж буй сургалтын өссөн дүнгээр 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авалтын мэдээллийг холбогдох талбарт мэдээлдэггүй байна. Тухайлбал тайланд онд ХТГИрээдүй ТББ-ийн түр хоноглох үйлчилгээний 34,390. мянга, АМЭсрэг МБ АССОЦИАЦИ ТББ-ийн түр хоноглох үйлчилгээний 5,910.0 мянга, УЗНийгэмлэг ТББ-ийн сургалт, үйлчилгээний 6,881.0 мянган төгрөгийн буюу нийт 47,181.0 мянган төгрөгийн 3 худалдан авалтыг мэдээлээгүй байна. Мөн цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш зардлын 214,905.7 мянган төгрөгийн 28 гүйлгээг нөхөж мэдээлэв.

Энэ нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай нийцэхгүй байна.

## 2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, хяналт алдагдах, хууль тогтоомж зөрчих.

## 2.3. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэх талаар анхаарч, халамжийн үйлчилгээний 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авалтын мэдээллийг холбогдох талбарт мэдээлж байх.

## 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн захирагчийн 2021.02.24-ны өдрийн 01/290 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:

АУДИТЫН ТАЙЛАНГ

Ц.НАРМАНДАХ

Б.ЭРДЭНЭ

Г.ОРГИЛМӨРӨН 2021.02.24

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.19

Аудитын код: ОРА-2021/1/СТА-ЗГТС

Аудитын нэр: Орхон аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Шалгагдсан байгууллагын нэр: Орхон аймгийн Халамжийн сан.

(мянган төгрөг)

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Аймгийн Улаан загалмайн хорооноос зохион байгуулсан зорилтот сургалтад оролцогчдод олгогдоогүй унааны зардлын 390.0 мянган төгрөгийг нэг суралцагчийн сургалтын зардлын дээд хэмжээг хэтрүүлэн бичиг хэргийн болон цайны зардалд нэмж илүү олгосон байна.	390.0	Төлбөрийн акт тогтоох	ХХҮГ-ын дарга, Халамжийн сангийн мэргэжилтэн	Х.Эрдэнэбат, Б.Батбаатар
2	Халамжийн үйлчилгээ үзүүлэх олголтын жагсаалтаас 8,807.4 мянган төгрөгийн үйлчилгээг банк руу илгээсний дараа цуцлахдаа хэрхэн ямар шалтгаанаар цуцалснаа тайлбарлаагүй байна. Мөн халамжийн мөнгөний олголтыг банкнууд дээрх тухайлсан халамжийн сангийн данснаас шууд зарлага гаргаж олгож байгаа нь халамжийн мөнгө зорилтот иргэндээ хүрэхгүй байх эрсдэлийг нэмэгдүүлэхээс гадна халамжийн мөнгө бүгд иргэдийн дансанд шууд ордоггүйтэй холбоотойгоор өөрийн биеэр банк орж амжаагүй иргэдийн халамжийн мөнгийг олголтын жагсаалтаас банк руу илгээсний дараа цуцлаад, дахин өргөдөл гаргуулж /чирэгдэл учрах/ дараа жилийн төсвөөс нөхөж олгож байна.	8,807.4	Зөвлөмж өгөх	ХХҮГ-ын дарга, Халамжийн сангийн мэргэжилтэн	Х.Эрдэнэбат, Б.Батбаатар
3	Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшууллыг батлагдсан төсвөөс 391.2 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна.	391.2	Албан шаардлага өгөх	ХХҮГ-ын дарга, Халамжийн сангийн мэргэжилтэн	Х.Эрдэнэбат, Б.Батбаатар
4	Тайлант хугацаанд оруулбал зохих 149 талбарын мэдээллээс 5 талбарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Түр хоноглох үйлчилгээ болон ТББ-аас зохион байгуулж буй сургалтын өссөн дүнгээр 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авалтын мэдээллийг холбогдох талбарт мэдээлдэггүй байна. Тухайлбал тайланд онд ХТГИрээдүй ТББ-ийн түр хоноглох үйлчилгээний 34,390. мянга, АМЭсрэг МБ АССОЦИАЦИ ТББ-ийн түр хоноглох үйлчилгээний 5,910.0 мянга, УЗНийгэмлэг ТББ-ийн сургалт, үйлчилгээний 6,881.0 мянган төгрөгийн буюу нийт 47,181.0 мянган төгрөгийн 3 худалдан авалтыг мэдээлээгүй байна. Мөн цалингийн зардлаас бусад 5.0 сая	-	Зөвлөмж өгөх	ХХҮГ-ын дарга, Халамжийн сангийн мэргэжилтэн	Х.Эрдэнэбат, Б.Батбаатар





төгрөгөөс дээш зардлын 214,905.7 мянган төгрөгийн 28 гүйлгээг нөхөж мэдээлэв.				
<b>ДҮН</b>	<b>9,588.6</b>			

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор



Г.Оргилмөрөн

Б.Эрдэнэ

Ц.Нармандах